ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2023 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....3
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....8
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд....9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....10
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....11
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....11
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....12
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....12
3.4 Зээлийн чанарын талаар.....13
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....15
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....15
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....16
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....17
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....17
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....18
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....18
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА.....19
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....19
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....19
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....20
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....21
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....21

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024.02.02 Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 191 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид "ХЗХ" гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 ХЗХ буюу 2.6 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 47.6 хувь буюу 91 ХЗХ орон нутагт, 52.4 хувь буюу 100 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/



ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй буурсан боловч санхүүгийн болон статистик үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 4 улирал дараалан хангаагүй, өөрийн хөрөнгөгүй болсон, хоршоологчдын өмчгүй болж үйл ажиллагаа нь доголдсон ХЗХ-дын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой.

2023 онд нийт 58 ХЗХ-оос 96 хүсэлт ирүүлсэн бөгөөд тайлант улиралд 6 ХЗХ-оос ирүүлсэн сонгуульт гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, салбарын захирлын өөрчлөлт бүртгүүлэх 7 хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэлээ.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2019	2020	2021	2022	2023
ХЗХ-дын тоо	261	249	209	196	191
Шинээр олгосон	17	14	-	7	3
Хүчингүй болгосон	35	26	40	20	8
Түдгэлзүүлсэн	10	23	12	13	12
Сэргээсэн	1	6	1	3	1
ТЗ-ийн хугацаа сунгасан	52	49	85	62	-*

**Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.*

1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 191 ХЗХ, 61 салбар, 1,035 ажилтан, 72,521 гишүүн /72,253 иргэн, 268 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотод Багахангай дүүргээс бусад дүүрэгт 100 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 7 ХЗХ буюу 6.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт

Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 91 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Тус аймагт тусгай зөвшөөрөлтэй ХЗХ байхгүй боловч “Гялс төгрөг” ХЗХ-ны 6 салбар байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай аймагт тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт

1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 864 буюу 1.2 хувиар өсөж 72,521-т хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.4 хувь буюу 268 нь хуулийн этгээд, 54.4 хувь буюу 39,433 нь эмэгтэй гишүүд байна.

Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

Нийт гишүүдийн 54.2 хувь буюу 39,284 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 45.8 хувь буюу 33,237 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч 2019-2021 оны 4 дүгээр улирлын байдлаар гишүүдийн тоо тогтмол өсөж байсан бол 2022 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 5.0 хувь буурч, тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 191 ХЗХ-ны 31.9 хувь буюу 61 ХЗХ 20-100 гишүүнтэй, 51.8 хувь буюу 99 ХЗХ 101-500 гишүүнтэй, 9.4 хувь буюу 18 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 6.8 хувь буюу 13 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	61	3,366	4.6%
101-500 гишүүнтэй	99	21,590	29.8%
501-1,000 гишүүнтэй	18	12,637	17.4%
1,001-ээс дээш гишүүнтэй	13	34,928	48.2%
Нийт	**191**	**72,521**	**100.0%**

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 13 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 48.2 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



1.4 Бодлого, зохицуулалтын орчин

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- Азийн Хөгжлийн Банктай хамтран хэрэгжүүлж буй TA-6883REG: “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд хадгаламж, зээлийн хоршооны гишүүн эмэгтэй бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ногоон санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгааг хийж гүйцэтгэсэн. Суурь судалгааны үр дүнд үндэслэн хадгаламж, зээлийн хоршоодод ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх олон улсын туршлагыг нэвтрүүлэх боломжийн талаар 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр нийт хадгаламж зээлийн хоршоод, бодлого тодорхойлогч болон дэмжигч байгууллагын төлөөлөгчдийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- Азийн Хөгжлийн Банктай хамтран TA-9654MON “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийг хадгаламж, зээлийн хоршооны зах зээлд 2019-2023 онд амжилттай хэрэгжүүлж дуусгалаа.

Хууль, эрх зүйн орчин

- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн болон дагалдах хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо, зэрэг баримт бичгүүдийг эцэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарт тус тус хүргүүлсэн.

Хурал семинар, уулзалт

- Хорооны 2023 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын 2.1.16-д заасны дагуу Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан сургалтад “Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тойм” сэдвээр мэдээлэл өгч, 14 оролцогчид гэрчилгээ олгосон.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 191 ХЗХ-оос 2023 оны 4 дүгээр улирлын тайлангийн нэгтгэлд 8 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан.

2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 3: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	**191**	**100.0%**	**100**	**52.4%**	**91**	**47.6%**
Нийт гишүүдийн тоо	**72,521**	**100.0%**	**39,284**	**54.2%**	**33,237**	**45.8%**
Эрэгтэй	32,820	45.3%	16,172	49.3%	16,648	50.7%
Эмэгтэй	39,433	54.4%	22,914	58.1%	16,519	41.9%
Гишүүн хуулийн этгээд	268	0.4%	198	73.9%	70	26.1%
Гишүүдийн насжилт	**72,253**	**100.0%**	**39,086**	**54.1%**	**33,167**	**45.9%**
18-35 насны	19,431	26.9%	10,622	54.7%	8,809	45.3%
36-45 насны	21,713	30.1%	11,991	55.2%	9,722	44.8%
46-55 насны	16,972	23.5%	8,878	52.3%	8,094	47.7%
56-аас дээш	14,137	19.6%	7,595	53.7%	6,542	46.3%
Гишүүдийн боловсрол	**72,253**	**100.0%**	**39,086**	**54.1%**	**33,167**	**45.9%**
Дээд	32,626	45.2%	22,228	68.1%	10,398	31.9%
Тусгай дунд	11,096	15.4%	6,836	61.6%	4,260	38.4%
Бүрэн дунд	17,945	24.8%	8,651	48.2%	9,294	51.8%
Дунд	7,759	10.7%	1,206	15.5%	6,553	84.5%
Бага	2,827	3.9%	165	5.8%	2,662	94.2%
Нийт ажилтнуудын тоо	**1,035**	**100.0%**	**376**	**36.3%**	**659**	**63.7%**
Үүнээс: эмэгтэй	645	62.3%	273	42.3%	372	57.7%
Санхүүгийн програмтай	90	**47.1%**	**37**	**41.1%**	**53**	**58.9%**
Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	**14**	**100.0%**	**12**	**85.7%**	**2**	**14.3%**
Гүйлгээний тоо	386	100.0%	305	79.0%	81	21.0%
Гүйлгээний дүн /мян.төг/	20,126,801.59	100.0%	16,239,292.47	80.7%	3,887,509.13	19.3%
Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**
Сэжигтэй гүйлгээний тоо	0.00	0	0.00	0	0.00	0
Сэжигтэй гүйлгээний дүн /мян.төг/	0.00	0	0.00	0	0.00	0

2023 оны 4 дүгээр улиралд нийт ХЗХ-дын 7.3 хувь буюу 14 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 20,126,801.59 мянган төгрөгийн 386 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 80.7 хувь буюу 16,239,292.47 мянган төгрөгийн 305 гүйлгээг Улаанбаатар хотын 12 ХЗХ, 19.3 хувь буюу 3,887,509.13 мянган төгрөг бүхий 81 гүйлгээг орон нутгийн 2 ХЗХ мэдээлсэн.

ХЗХ-дын нийт гишүүдийн 56.9 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс харьцангуй залуу байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн насжилт, УБ, орон нутгаар



Нийт гишүүдийн 45.2 хувь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 68.1 хувь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

График 5: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар



Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	**191**	**100.0%**	**100**	**52.4%**	**91**	**47.6%**
Нийт зээлийн үлдэгдэл	**209,080,409.87**	**100.0%**	**156,644,871.60**	**74.9%**	**52,435,538.26**	**25.1%**
Нийт зээлдэгчийн тоо	**29,515**	**100.0%**	**13,307**	**45.1%**	**16,208**	**54.9%**
Иргэн	29,424	99.7%	13,236	99.5%	16,188	99.9%
Эмэгтэй	16,766	56.8%	8,028	60.3%	8,738	53.9%
Хуулийн этгээд	91	0.3%	71	0.5%	20	0.1%
Зээлдэгчдийн насжилт	**29,424**	**100.0%**	**13,236**	**45.0%**	**16,188**	**55.0%**
18-35 насны	7,977	27.1%	3,926	29.7%	4,051	25.0%
36-45 насны	9,327	31.7%	4,473	33.8%	4,854	30.0%
46-55 насны	8,157	27.7%	3,556	26.9%	4,601	28.4%
56-аас дээш	3,963	13.5%	1,281	9.7%	2,682	16.6%
Зээлдэгчдийн боловсрол	**29,424**	**100.0%**	**13,236**	**45.0%**	**16,188**	**55.0%**
Дээд	11,098	37.7%	6,092	46.0%	5,006	30.9%
Тусгай дунд	5,902	20.1%	3,177	24.0%	2,725	16.8%
Бүрэн дунд	6,956	23.6%	2,128	16.1%	4,828	29.8%
Дунд	4,269	14.5%	1,764	13.3%	2,505	15.5%
Бага	1199	4.1%	75	0.6%	1,124	6.9%

Тайлант улиралд ХЗХ-д 29,515 зээлдэгчийн 209,080,409.87 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 45.1 хувь буюу 13,307 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 74.9 хувь буюу 156,644,871.60 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 54.9 хувь буюу 16,208 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 25.1 хувь буюу 52,435,538.26 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.7 хувь буюу 29,424 нь хувь хүн (56.8 хувь буюу 16,766 нь эмэгтэй), 0.3 хувь буюу 91 нь хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 7,083.93 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 11,771.61 мянган төгрөг, орон нутагт 3,235.16 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	**191**	**100.0%**	**100**	**52.4%**	**91**	**47.6%**
Нийт хадгаламжийн үлдэгдэл	**215,159,878.63**	**100.0%**	**171,311,064.76**	**79.6%**	**43,848,813.88**	**20.4%**
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	43,294	100.0%	23,043	53.2%	20,251	46.8%
Эмэгтэй	25,133	58.1%	12,922	56.1%	12,211	60.3%

Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	**5,493,964.09**	**2.6%**	**4,960,939.42**	**2.9%**	**533,024.66**	**1.2%**
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	4,885	11.3%	3,769	16.4%	1,116	5.5%
Иргэн	4,864	11.2%	3,750	16.3%	1,114	5.5%
Хуулийн этгээд	21	0.0%	19	0.1%	2	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	**209,665,914.55**	**97.4%**	**166,350,125.33**	**97.1%**	**43,315,789.21**	**98.8%**
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	38,409	88.7%	19,274	83.6%	19,135	94.5%
Иргэн	38,358	88.6%	19,257	83.6%	19,101	94.3%
Хуулийн этгээд	51	0.1%	17	0.1%	34	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	**43,222**	**100.0%**	**23,007**	**100.0%**	**20,215**	**100.0%**
18-35 насны	16,321	37.8%	10,605	46.1%	5,716	28.3%
36-45 насны	11,029	25.5%	5,472	23.8%	5,557	27.5%
46-55 насны	8,794	20.3%	3,766	16.4%	5,028	24.9%
56-аас дээш	7,078	16.4%	3,164	13.8%	3,914	19.4%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	**43,222**	**100.0%**	**23,007**	**100.0%**	**20,215**	**100.0%**
Дээд	19,609	45.4%	13,313	57.9%	6,296	31.1%
Тусгай дунд	6,664	15.4%	3,850	16.7%	2,814	13.9%
Бүрэн дунд	8,595	19.9%	3,208	13.9%	5,387	26.6%
Дунд	4,751	11.0%	928	4.0%	3,823	18.9%
Бага	3,603	8.3%	1,708	7.4%	1,895	9.4%

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 43,294 хадгаламж эзэмшигчийн 215,159,878.63 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 53.2 хувь буюу 23,043 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 79.6 хувь буюу 171,311,064.76 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 46.8 хувь буюу 20,251 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 20.4 хувь буюу 43,848,813.88 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 11.3 хувийг хугацаагүй, 88.7 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 43,222 нь хувь хүн (58.1 хувь буюу 25,133 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 72 нь хуулийн этгээд байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 4,969.74 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,434.41 мянган төгрөг, орон нутагт 2,165.27 мянган төгрөг байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 306,475,284.23 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.5 хувь буюу 38,759,614.81 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.5 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 0.5 хувь буюу 1,184,825.94 мянган төгрөгөөр буурсан бол нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 14.8 хувь буюу 27,659,301.41 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 9.6 хувь буюу 5,671,979.62 мянган төгрөгөөр, нийт зарлага 13.4 хувь буюу 6,331,982.76 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол нийт цэвэр орлого 5.7 хувь буюу 660,003.13 мянган төгрөгөөр буурч 10,956,369.99 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 52.9 хувь буюу 101 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны IV улирал	2023 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	**267,715,669.75**	**306,475,284.56**	38,759,614.81	14.5%
Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.5%		
Нийт зээл	**210,229,235.80**	**209,080,409.87**	-1,148,825.94	-0.5%
Банкны салбарт эзлэх хувь	0.9%	0.8%		
Нийт чанаргүй зээл	**7,046,472.75**	**6,675,552.76**	-370,919.99	-5.3%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.4%	3.2%	-0.2%	-4.7%
Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.3%	0.0%	-5.8%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	**187,500,577.22**	**215,159,878.63**	27,659,301.41	14.8%
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.0%		
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	**25,902,489.10**	**27,535,066.83**	1,632,577.73	6.3%
Нийт хоршоологчдын өмч	**33,680,259.92**	**41,764,090.59**	8,083,830.66	24.0%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	**5,570,416.63**	**3,324,514.76**	-2,245,901.86	-40.3%
Нийт орлого	58,953,057.71	64,625,037.33	5,671,979.62	9.6%
Нийт зарлага	47,336,684.58	53,668,667.34	6,331,982.76	13.4%
Цэвэр орлого, алдагдал	**11,616,373.13**	**10,956,369.99**	-660,003.13	-5.7%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 100 ХЗХ-ны нийт хөрөнгө 239,239,093.34 мянган төгрөг нь зах зээлийн 78.1 хувь, нийт зээл 156,644,871.60 мянган төгрөг нь зах зээлийн 74.9 хувь, нийт хадгаламж 171,311,064.76 мянган төгрөг нь зах зээлийн 79.6 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.0 хувь буюу 282,947.51 мянган төгрөгөөр өсөж 5,951,690.17 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.8 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 45.2 хувь буюу 2,504,736.71 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 9.2 хувь буюу 4,021,553.29 мянган төгрөгөөр, нийт зарлага 14.4 хувь буюу 5,110,377.76 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн боловч нийт цэвэр орлого 13.1 хувь буюу 1,088,824.47 мянган төгрөгөөр буурч 7,198,078.58 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 54.0 хувь буюу 54 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны IV улирал	2023 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	**209,247,734.43**	**239,239,093.34**	**29,991,358.91**	**14.3%**
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	78.2%	78.1%	-0.1%	-0.1%
Нийт зээл	**162,622,621.47**	**156,644,871.60**	**-5,977,749.87**	**-3.7%**
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	77.4%	74.9%	-2.4%	-3.1%
Нийт чанаргүй зээл	**5,668,742.66**	**5,951,690.17**	**282,947.51**	**5.0%**
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	80.4%	89.2%	8.7%	10.8%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.5%	3.8%	0.3%	9.0%

Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	**148,965,151.87**	**171,311,064.76**	**22,345,912.89**	**15.0%**
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	79.4%	79.6%	0.2%	0.2%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	**19,399,941.56**	**20,186,991.83**	**787,050.27**	**4.1%**
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	74.9%	73.3%	-1.6%	-2.1%
Нийт хоршоологчдын өмч	**24,126,395.50**	**30,289,919.66**	**6,163,524.16**	**25.5%**
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	71.6%	72.5%	0.9%	1.2%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	**5,540,416.63**	**3,035,679.92**	**-2,504,736.71**	**-45.2%**
Нийт орлого	43,685,793.09	47,707,346.38	4,021,553.29	9.2%
Нийт зарлага	35,398,890.04	40,509,267.80	5,110,377.76	14.4%
Цэвэр орлого, алдагдал	**8,286,903.05**	**7,198,078.58**	**-1,088,824.47**	**-13.1%**

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 91 ХЗХ-ны нийт хөрөнгө 67,236,191.22 мянган төгрөг нь зах зээлийн 21.9 хувь, нийт зээлийн үлдэгдэл 52,435,538.26 мянган төгрөг нь зах зээлийн 25.1 хувь, нийт хадгаламж 43,848,813.88 мянган төгрөг нь зах зээлийн 20.4 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 10.8 хувь буюу 1,650,426.34 мянган төгрөгөөр, нийт зарлага 10.2 хувь буюу 1,221,605.00 мянган төгрөгөөр тус тус өсөж, цэвэр орлого 3,758,291.42 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 51.6 хувь буюу 47 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны IV улирал	2023 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	**58,467,935.32**	**67,236,191.22**	**8,768,255.90**	**15.0%**
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	21.8%	21.9%	0.1%	0.5%
Нийт зээл	**47,606,614.33**	**52,435,538.26**	**4,828,923.93**	**10.1%**
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	22.6%	25.1%	2.4%	10.7%
Нийт чанаргүй зээл	**1,377,730.09**	**723,862.59**	**-653,867.49**	**-47.5%**
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	19.6%	10.8%	-8.7%	-44.5%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.8%	0.5%	-0.4%	-45.5%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	**38,535,425.35**	**43,848,813.88**	**5,313,388.52**	**13.8%**
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	20.6%	20.4%	-0.2%	-0.8%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	**6,502,547.54**	**7,348,075.00**	**845,527.46**	**13.0%**
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	25.1%	26.7%	1.6%	6.3%
Нийт хоршоологчдын өмч	**9,553,864.42**	**11,474,170.93**	**1,920,306.51**	**20.1%**
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	28.4%	27.5%	-0.9%	-3.1%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	**30,000.00**	**288,834.85**	**258,834.85**	**862.8%**
Нийт орлого	15,267,264.62	16,917,690.96	1,650,426.34	10.8%
Нийт зарлага	11,937,794.54	13,159,399.54	1,221,605.00	10.2%
Цэвэр орлого, алдагдал	**3,329,470.08**	**3,758,291.42**	**428,821.34**	**12.9%**

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2022 оны IV улирал		2023 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	**263,615,793.41**	**98.5%**	**302,433,000.65**	**98.7%**	**38,817,207.24**	**14.7%**
Мөнгөн хөрөнгө	**39,998,061.49**	**14.9%**	**75,561,585.53**	**24.7%**	**35,563,524.04**	**88.9%**
Бэлэн мөнгө	5,389,574.22	2.0%	3,700,642.83	1.2%	-1,688,931.40	-31.3%
Банкинд байршуулсан харилцах	13,877,483.04	5.2%	14,687,071.64	4.8%	809,588.61	5.8%
Банкинд байршуулсан хадгаламж	20,731,004.23	7.7%	57,173,871.06	18.7%	36,442,866.83	175.8%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	**650,000.00**	**0.2%**	**900,000.00**	**0.3%**	**250,000.00**	**38.5%**
Арилжааны үнэт цаас	650,000.00	0.2%	900,000.00	0.3%	250,000.00	38.5%
Зээл /цэврээр/	**204,972,547.37**	**76.6%**	**204,238,272.48**	**66.6%**	**-734,274.89**	**-0.4%**
Нийт зээл	210,229,235.80	78.5%	209,080,409.87	68.2%	-1,148,825.94	-0.5%
Хэвийн зээл	197,245,086.74	73.7%	193,870,730.72	63.3%	-3,374,356.03	-1.7%
Хугацаа хэтэрсэн зээл	5,937,676.31	2.2%	8,534,126.39	2.8%	2,596,450.08	43.7%
Чанаргүй зээл	7,046,472.75	2.6%	6,675,552.76	2.2%	-370,919.99	-5.3%
(Зээлийн эрсдэлийн сан)	5,256,688.43	2.0%	4,842,137.38	1.6%	-414,551.05	-7.9%
Авлага	**15,800,561.53**	**5.9%**	**17,225,449.75**	**5.6%**	**1,424,888.22**	**9.0%**
Байгууллага, хүмүүсээс авах авлага	7,639,762.51	2.9%	6,646,112.59	2.2%	-993,649.92	-13.0%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,160,799.02	3.0%	10,579,337.16	3.5%	2,418,538.14	29.6%
Бусад эргэлтийн хөрөнгө	**1,286,006.62**	**0.5%**	**3,560,664.19**	**1.2%**	**2,274,657.57**	**176.9%**
Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр/	**908,616.39**	**0.3%**	**947,028.69**	**0.3%**	**38,412.30**	**4.2%**
Өмчлөх бусад хөрөнгө	946,929.71	0.4%	985,217.74	0.3%	38,288.03	4.0%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	38,313.32	0.0%	38,189.05	0.0%	-124.27	-0.3%
Эргэлтийн бус хөрөнгө	**4,099,876.35**	**1.5%**	**4,042,283.91**	**1.3%**	**-57,592.43**	**-1.4%**
Үндсэн хөрөнгө /цэвэр/	**3,923,987.47**	**1.5%**	**3,887,594.18**	**1.3%**	**-36,393.29**	**-0.9%**
Үндсэн хөрөнгө	6,165,274.45	2.3%	6,482,804.44	2.1%	317,529.99	5.2%
(Хуримтлагдсан элэгдэл)	2,241,286.97	0.8%	2,595,210.26	0.8%	353,923.29	15.8%
Биет бус хөрөнгө	**160,386.18**	**0.1%**	**139,187.05**	**0.0%**	**-21,199.14**	**-13.2%**
Биет бус хөрөнгө	314,658.39	0.1%	327,624.99	0.1%	12,966.59	4.1%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	154,272.21	0.1%	188,437.94	0.1%	34,165.73	22.1%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	**15,502.69**	**0.0%**	**15,502.69**	**0.0%**	**0**	**0.0%**
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,502.69	0.0%	15,502.69	0.0%	0	0.0%
Хөрөнгийн дүн	**267,715,669.75**	**100.0%**	**306,475,284.56**	**100.0%**	**38,759,614.81**	**14.5%**

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 306,475,284.56 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.5 хувь буюу 38,759,614.81 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 98.7 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.3 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 24.7 хувийг, цэвэр зээл 66.6 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.5 хувь буюу 1,148,825.94 мянган төгрөгөөр буурч 209,080,409.87 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 4,842,137.38 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 204,238,272.48 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.7 хувь буюу 2,596,450.08 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2019 оноос тайлант улирал хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо тогтмол буурсан ч хөрөнгийн хэмжээ 37.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 6: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 177,766,469.24 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 58.0 хувийг, гишүүдийн тоо 19,057 байгаа нь нийт гишүүдийн 26.9 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	177,766,469.24	58.0%	19,057	26.3%
2	1,000,000.0 -10,000,000.0	29	93,357,185.56	30.5%	25,682	35.4%
3	500,000.0-1,000,000.0	21	14,927,289.16	4.9%	8,545	11.8%
4	100,000.0-500,000.0	74	16,728,499.38	5.5%	14,205	19.6%
5	50,000.0-100,000.0	40	3,015,083.24	1.0%	3,527	4.9%
6	10,000.0-50,000.0	21	671,723.30	0.2%	1,440	2.0%
7	10,000.0 хүртэл	2	9,034.67	0.00%	65	0.1%
	Нийт дүн	**191**	**306,475,284.56**	**100.0%**	**72,521**	**100.0%**

3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 209,080,409.87 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 68.2 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 204,238,272.48 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 66.6 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.28 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.43 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 28 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 85.0 хувийг бүрдүүлж байна. Тайлант улиралд 3 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	28	177,681,972.79	85.0%
2	500,000.0-1,000,000.0	14	10,630,844.91	5.1%
3	100,000.0-500,000.0	72	16,973,816.52	8.1%
4	50,000.0-100,000.0	39	2,768,350.06	1.3%
5	10,000.0-50,000.0	32	1,001,319.32	0.5%
6	10,000.0 хүртэл	3	24,106.26	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	3	-	-
	Нийт дүн	**191**	**209,080,409.87**	**100%**

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	**29,515**	**100.0%**	**209,080,409.87**	**100.0%**
Хэвийн	27,487	93.1%	193,870,730.72	92.7%
Хугацаа хэтэрсэн	670	2.3%	8,534,126.39	4.1%
Чанаргүй	1,358	4.6%	6,675,552.76	3.2%
Хэвийн бус	*333*	*24.5%*	*1,714,893.37*	*25.7%*
Эргэлзээтэй	*393*	*28.9%*	*2,128,571.79*	*31.9%*
Муу	*632*	*46.5%*	*2,832,087.59*	*42.4%*

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 92.7 хувь буюу 193,870,730.72 мянган төгрөгийг хэвийн зээл, 4.1 хувь буюу 8,534,126.39 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.2 хувь буюу 6,675,552.76 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 15,209,679.15 мянган төгрөгийн үлдэгдэлд 31.8 хувь буюу 4,842,137.38 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 93.1 хувийг хэвийн, 2.3 хувийг хугацаа хэтэрсэн, 4.6 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,358 зээлдэгчийн 6,675,552.76 мянган төгрөгийн үлдэгдлийн 24.5 хувийг хэвийн бус, 28.9 хувийг эргэлзээтэй, 46.5 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 1.1 пунктээр буурч 92.7 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 1.3 пунктээр нэмэгдэж 4.1 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.2 пунктээр буурч 3.2 хувьд хүрсэн байна.

График 7: Зээлийн чанар



Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт	**156,644,871.60**	**100.0%**	**74.9%**	**52,435,538.26**	**100.0%**	**25.1%**
Хэвийн	143,619,275.56	91.7%	74.1%	50,251,455.15	95.8%	25.9%
Хугацаа хэтэрсэн	7,073,905.87	4.5%	82.9%	1,460,220.52	2.8%	17.1%
Чанаргүй	5,951,690.17	3.8%	89.2%	723,862.59	1.4%	10.8%
Хэвийн бус	*1,370,129.14*	*23.0%*	*79.9%*	*344,764.24*	*47.6%*	*20.1%*
Эргэлзээтэй	*1,921,739.90*	*32.3%*	*90.3%*	*206,831.89*	*28.6%*	*9.7%*
Муу	*2,659,821.13*	*44.7%*	*93.9%*	*172,266.46*	*23.8%*	*6.1%*

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал ХЗХ-ны зах зээлийн нийт зээлийн 74.9 хувь буюу 156,644,871.60 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-д, 25.1 хувь буюу 52,435,538.26 мянган төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 91.7 хувь буюу 143,619,275.56 мянган төгрөгийг хэвийн, 4.5 хувь буюу 7,073,905.87 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 3.8 хувь буюу 5,951,690.17 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 44.7 хувь буюу

2,659,821.13 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд зах зээлийн нийт муу зээлийн 93.9 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 95.8 хувь буюу 50,251,455.15 мянган төгрөгийг хэвийн, 2.8 хувь буюу 1,460,220.52 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 1.4 хувь буюу 723,862.59 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

График 8: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



ХЗХ-дын зээлийн багц 2021 оны 4 дүгээр улирал хүртэл тогтмол өсөлттэй байсан бол тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурсан үзүүлэлттэй байгааг график 9-д харуулав.

Хүснэгт 14: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	9,021,165.25	16,299,869.72	15,609,093.71	9,711,941.27	4.6%
2	Уул уурхай, олборлолт	1,543,111.81	2,401,226.90	2,320,404.35	1,623,934.36	0.8%
3	Боловсруулах үйлдвэрлэл	1,325,550.40	726,664.75	1,410,945.71	641,269.44	0.3%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	436,421.53	370,222.20	534,949.39	271,694.34	0.1%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1,820,732.49	3,120,361.30	3,486,173.73	1,454,920.06	0.7%
6	Барилга	6,482,611.74	9,859,111.30	8,822,984.91	7,518,738.13	3.6%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	16,782,327.32	39,337,283.74	37,646,304.82	18,473,306.24	8.8%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	5,036,064.60	13,446,873.11	12,770,865.76	5,712,071.95	2.7%
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	6,363,523.85	22,073,109.60	23,912,269.94	4,524,363.50	2.2%
10	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	4,014,131.21	6,000,553.00	4,298,537.36	5,716,146.85	2.7%
11	Мэдээлэл холбоо	4,988,943.47	1,140,460.00	3,990,891.86	2,138,511.61	1.0%
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	19,211,170.19	56,039,373.06	37,396,822.86	37,853,720.39	18.1%
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	927,005.97	775,817.49	892,699.40	810,124.06	0.4%
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	640,879.42	489,250.00	640,750.20	489,379.22	0.2%
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	348,195.96	121,006.00	210,047.67	259,154.29	0.1%
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	38,628.89	11,500.00	44,081.78	6,047.10	0.0%
17	Боловсрол	1,256,873.30	2,162,579.98	1,978,386.45	1,441,066.84	0.7%
18	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	940,622.53	1,567,703.00	1,432,803.39	1,075,522.14	0.5%
19	Бусад	128,841,041.16	143,375,991.74	162,858,534.83	109,358,498.07	52.3%
	Үүнээс: Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл	24,808,786.56	52,942,154.85	56,941,651.08	20,809,290.33	10.0%
	НИЙТ	**210,019,001.09**	**319,318,956.89**	**320,257,548.12**	**209,080,409.87**	**100.0%**

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д нийт 319,318,956.89 мянган төгрөгийн зээл олгож, 320,257,548.12 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлттэй, 209,080,409.87 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг зээлийн бүтээгдэхүүнээр ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 52.3 хувь буюу 109,358,498.07 мянган төгрөгийг бусад, 18.1 хувь буюу 37,853,720.39 мянган төгрөгийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 8.8 хувь буюу 18,473,306.24 мянган төгрөгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 4.6 хувь буюу 9,711,941.27 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 3.6 хувь буюу 7,518,738.13 мянган төгрөгийг барилгын зориулалтаар тус тус авсан байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 10.0 хувь буюу 20,809,290.33 мянган төгрөгийг хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл эзэлж байна.

ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар

Хүснэгт 15: ХЗХ-дын эх үүсвэрийн бүтэц /мянган төгрөгөөр/

ЭХ ҮҮСВЭР	2022 оны IV улирал		2023 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Өр төлбөр	**207,939,351.05**	**77.7%**	**236,987,363.46**	**77.3%**	**29,048,012.40**	**14.0%**
Хадгаламж	**187,500,577.22**	**70.0%**	**215,159,878.63**	**70.2%**	**27,659,301.41**	**14.8%**
Хугацаагүй	2,814,882.69	1.1%	5,493,964.09	1.8%	2,679,081.40	95.2%
Хугацаатай	184,685,694.53	69.0%	209,665,914.55	68.4%	24,980,220.02	13.5%
Богино хугацаат зээл	**2,608,334.25**	**1.0%**	**2,282,263.31**	**0.7%**	**-326,070.94**	**-12.5%**
Бусад богино хугацаат өр төлбөр	**14,696,806.98**	**5.5%**	**18,395,293.93**	**6.0%**	**3,698,486.94**	**25.2%**
Урт хугацаат өр төлбөр	**3,133,632.60**	**1.2%**	**1,149,927.58**	**0.4%**	**-1,983,705.02**	**-63.3%**
Өөрийн хөрөнгө	**59,776,318.70**	**22.3%**	**69,487,921.11**	**22.7%**	**9,711,602.41**	**16.2%**
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	**25,902,489.10**	**9.7%**	**27,535,066.83**	**9.0%**	**1,632,577.73**	**6.3%**
Гишүүний оруулсан хувь хөрөнгө	25,730,000.41	9.6%	27,300,834.99	8.9%	1,570,834.58	6.1%
Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө	172,488.69	0.1%	234,231.84	0.1%	61,743.15	35.8%
Дахин үнэлгээний нэмэгдэл	**193,569.68**	**0.1%**	**188,763.69**	**0.1%**	**-4,805.99**	**-2.5%**
Хоршоологчдын өмч	**33,680,259.92**	**12.6%**	**41,764,090.59**	**13.6%**	**8,083,830.66**	**24.0%**
Нөөцийн сан	10,871,044.69	4.1%	12,657,998.94	4.1%	1,786,954.25	16.4%
Хандив, тусламж	323,620.92	0.1%	240,051.92	0.1%	-83,569.01	-25.8%
Хадгаламж, хамгаалалтын сан	2,594,346.90	1.0%	2,869,050.34	0.9%	274,703.44	10.6%
Нийгмийн хөгжлийн сан	950,753.21	0.4%	969,119.12	0.3%	18,365.92	1.9%
Тогтворжилтын сан	2,645,020.16	1.0%	2,830,490.75	0.9%	185,470.59	7.0%
Бусад сангууд	1,645,092.03	0.6%	2,174,795.14	0.7%	529,703.11	32.2%
Хуримтлагдсан орлого /алдагдал/	14,650,382.01	5.5%	20,022,584.37	6.5%	5,372,202.36	36.7%
Тайлангийн үеийн цэвэр орлого	11,616,373.13	4.3%	10,956,369.99	3.6%	-660,003.13	-5.7%
Өмнөх үеийн цэвэр орлого	3,034,008.88	1.1%	9,066,214.38	3.0%	6,032,205.50	198.8%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	**267,715,669.75**	**100.0%**	**306,475,284.56**	**100.0%**	**38,759,614.81**	**14.5%**

Зах зээлийн нийт өр төлбөр 236,987,363.46 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.0 хувь буюу 29,048,012.40 мянган төгрөгөөр, өөрийн хөрөнгө 69,487,921.11 мянган төгрөг нь 16.2 хувь буюу 9,711,602.41 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн бүтцийн 77.3 хувийг өр төлбөр, 22.7 хувийг өөрийн хөрөнгөө бүрдүүлж байна.

График 9: Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламж, гишүүдийн хувь хөрөнгө, хоршоологчдын өмч, бусад өр төлбөр, дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 2019 оноос 2021 он хүртэл тогтмол өсөлттэй байсан бол 2022 онд гишүүдийн хувь хөрөнгөөс бусад үзүүлэлт 7.9-15.0 хувиар буурсан байна. Тайлант улиралд хадгаламж 14.8 хувиар, гишүүдийн хувь хөрөнгө 6.3 хувиар, хоршоологчдын өмч 24.0 хувиар, бусад өр төлбөр 6.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

ХЗХ-ны зах зээлийн татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 215,159,878.63 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 70.2 хувийг эзэлж байна. Нийт хадгаламжийн 97.4 хувийг хугацаатай хадгаламж, 2.6 хувийг хугацаагүй хадгаламж тус тус бүрдүүлж байна.

Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын 1.33 хувь, тайлант улиралд татан төвлөрүүлсэн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 1.34 хувь байна.

Хүснэгт 16: ХЗХ-дын хадгаламж, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хадгаламжийн хэмжээ	ХЗХ-д	Хадгаламжийн дүн	Эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	4	132,792,121.08	61.7%
2	1,000,000.0-10,000,000.0	17	55,026,758.84	25.6%
3	500,000.0-1,000,000.0	14	10,393,961.20	4.8%
4	100,000.0-500,000.0	52	13,314,669.87	6.2%
5	50,000.0-100,000.0	26	1,986,370.60	0.9%
6	10,000.0-50,000.0	59	1,562,435.30	0.7%
7	5,000.0-10,000.0	8	60,706.53	0.0%
8	5,000.0 хүртэл	9	22,855.21	0.0%
9	Хадгаламжгүй	2	-	-
	Нийт дүн	**191**	**215,159,878.63**	**100.0%**

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн дүнгээр 10 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжтай 4 ХЗХ-ны хадгаламж нийт ХЗХ-дын хадгаламжийн дүнгийн 61.7 хувийг эзэлж байна.

График 10: ХЗХ-ны зах зээлийн хадгаламжийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



Зах зээлийн нийт хадгаламжийн хэмжээ сүүлийн 5 жилд дунджаар 7.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар

Хүснэгт 17: ХЗХ-дын бусдаас авсан зээл, өр төлбөрийн бүтэц /мянган төгрөгөөр/

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	2022 оны IV улирал		2023 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Богино хугацаат зээл, өр төлбөр	**2,608,334.25**	**45.4%**	**2,282,263.31**	**66.5%**	**- 326,070.94**	**-12.5%**
Банкнаас авсан зээл	717,000.00	12.5%	576,931.42	16.8%	-140,068.58	-19.5%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	522,000.00	9.1%	522,000.00	15.2%	-	0.0%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	1,369,334.25	23.8%	1,183,331.89	34.5%	-186,002.35	-13.6%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	-
Урт хугацаат зээл, өр төлбөр	**3,133,632.60**	**54.6%**	**1,149,927.58**	**33.5%**	**-1,983,705.02**	**-63.3%**
Банкнаас авсан зээл	1,999,998.04	34.8%	98,834.85	2.9%	-1,901,163.19	-95.0583%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	12,283.65	0.2%	41,683.65	1.2%	29,400.00	239.3%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	949,800.69	16.5%	901,732.95	26.3%	-48,067.73	-5.1%
Тогтворжилтын сангийн туслалцаа	104,558.28	1.8%	-	0.0%	-104,558.28	-100.0%
Хойшлогдсон татварын өр төлбөр	66,991.94	1.2%	107,676.13	3.1%	40,684.20	60.7%
Нийт дүн	**5,741,966.85**	**100.0%**	**3,432,190.90**	**100.0%**	**-2,309,775.95**	**-40.2%**

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын бусдаас авсан зээлийн үлдэгдэл 3,432,190.90 мянган төгрөг байгаа нь зах зээлийн нийт хөрөнгийн 1.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.2 хувь буюу 2,309,775.95 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант улиралд бусдаас авсан нийт зээлийн 66.5 хувийг богино хугацаат зээл, 33.5 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус бүрдүүлж байна. Богино хугацаат зээл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12.5 хувь буюу 326,070.94 мянган төгрөгөөр, урт хугацаат өр төлбөр 63.3 хувь буюу 1,983,705.02 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 18: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц, хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	Нийт		УБ		Орон нутаг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Банкнаас авсан зээл	675,766.26	19.7%	436,931.42	13.9%	238,834.85	81.3%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	563,683.65	16.4%	523,683.65	16.7%	40,000.00	13.6%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	2,085,064.84	60.8%	2,075,064.84	66.1%	10,000.00	3.4%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Хойшлогдсон татварын өр төлбөр	107,676.13	3.1%	102,587.47	3.3%	5,088.67	1.7%
Нийт дүн	**3,432,190.90**	**100.0%**	**3,138,267.39**	**100.0%**	**293,923.51**	**100.0%**

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд банкнаас авсан зээл 19.7 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 16.4 хувь, төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 60.8 хувь, хойшлогдсон татварын өр төлбөр 3.1 хувийг тус тус эзэлж байна. Бусдаас авсан нийт зээлийн 91.4 хувийг Улаанбаатар хотын ХЗХ-дын зээл, 8.6 хувийг орон нутгийн ХЗХ-дын зээл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын бусдаас авсан зээлийн 13.9 хувийг банкнаас авсан зээл, 16.7 хувийг санхүүгийн байгууллагаас авсан зээл, 66.1 хувийг төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ, 3.3 хувийг хойшлогдсон татварын өр төлбөр тус тус эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд банкнаас авсан зээл 81.3 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 13.6 хувь, төсөл, хөтөлбөрөөс авсан зээл 3.4 хувь, хойшлогдсон татварын өр төлбөр 1.7 хувийг тус тус эзэлж байна.

4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар

Хүснэгт 19: ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөрийн бүтэц /мянган төгрөгөөр/

БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2022 оны IV улирал		2023 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Цалингийн өглөг	117,772.95	0.8%	115,629.56	0.63%	-2,143.39	-1.8%

Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	1,178,133.34	8.0%	1,317,245.91	7.16%	139,112.57	11.8%
Ногдол ашгийн өглөг	217,569.47	1.5%	279,217.52	1.52%	61,648.05	28.3%
Санхүүгийн түрээсийн өглөг	26,766.03	0.2%	0.00	0.00%	-26,766.03	-100.0%
Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	0.00	0.0%	0.00	0.00%	0.00	0.00
Урьдчилж орсон орлого	86,228.08	0.6%	152,357.65	0.83%	66,129.58	76.7%
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	11,886,035.20	80.9%	14,405,830.14	78.31%	2,519,794.94	21.2%
Салбар хоорондын тооцоогоорх өглөг	0.00	0.0%	0.00	0.00%	0.00	0.00
Бусад богино хугацаат өглөг	1,184,301.91	8.1%	2,125,013.14	11.55%	940,711.23	79.4%
Нийт дүн	**14,696,806.98**	**100.0%**	**18,395,293.93**	**100.0%**	**3,698,486.94**	**25.2%**

Тайлант улиралд ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөр 18,395,293.93 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,698,489.94 мянган төгрөг буюу 25.2 хувиар өссөн бөгөөд зах зээлийн нийт хөрөнгийн 6.0 хувийг эзэлж байна.

4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ 27,535,066.83 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 9.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 20: ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо		Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн		Нэг гишүүнд ногдох хувь хөрөнгө
			Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн
1	1,000,000.0 дээш	4	19,644	27.1%	12,992,001.02	47.2%	661.37
2	500,000.0-1,000,000.0	5	1,646	2.3%	3,471,760.80	12.6%	2,109.21
3	100,000.0-500,000.0	27	22,087	30.5%	6,021,603.27	21.9%	272.63
4	50,000.0-100,000.0	38	12,812	17.7%	2,652,818.13	9.6%	207.06
5	10,000.0-50,000.0	89	14,307	19.7%	2,215,934.72	8.0%	154.88
6	5,000.0-10,000.0	22	1,735	2.4%	159,218.77	0.6%	91.77
7	5,000.0 хүртэл	6	290	0.4%	21,730.12	0.1%	74.93
Нийт дүн		**191**	**72,521**	**100.0%**	**27,535,066.83**	**100.0%**	**379.68**

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө 100.0 сая төгрөгөөс дээш 36 ХЗХ

ХЗХ-ны зах зээлийн гишүүдийн оруулсан нийт хувь хөрөнгийн 81.7%

Нийт гишүүдийн 59.8%

4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 69,487,921.11 мянган төгрөгт хүрч, нийт эх үүсвэрийн 22.7 хувийг эзэлж байна.

Тайлант улиралд 9 ХЗХ-ны нийт өр төлбөрийн хэмжээ нийт хөрөнгөөс хэтэрсэн буюу өөрийн хөрөнгөгүй болсон ба үүнээс 7 ХЗХ "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд байгуулагдсан байна.

Хүснэгт 21: ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	9	42,279,945.18	60.8%
2	500,000.0-1,000,000.0	15	11,744,504.78	16.9%
3	100,000.0-500,000.0	54	11,382,971.25	16.4%
4	50,000.0-100,000.0	38	2,731,768.55	3.9%
5	10,000.0-50,000.0	55	1,627,399.38	2.3%
6	10,000.0 доош	11	64,543.07	0.1%
7	Өөрийн хөрөнгөгүй	9	-343,211.11	-0.5%
Нийт дүн		**191**	**69,487,921.11**	**100.0%**

Хүснэгт 22: ХЗХ-дын хоршоологчдын өмч, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	5	24,162,202.32	57.9%
2	500,000.0-1,000,000.0	7	4,830,101.30	11.6%
3	100,000.0-500,000.0	44	10,087,564.01	24.2%
4	50,000.0-100,000.0	22	1,484,805.14	3.6%
5	10,000.0-50,000.0	65	1,587,757.91	3.8%
6	5,000.0-10,000.0	13	105,329.90	0.3%
7	1,000.0-5,000.0	17	50,830.13	0.1%
8	1,000.0 хүртэл	1	-	0.0%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	17	(544,500.11)	-1.3%
	Нийт дүн	**191**	**41,764,090.59**	**100%**

Тайлант улиралд нийт 17 ХЗХ алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 ХЗХ буюу 10.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

5.1 ХЗХ-дын орлогын талаар

Тайлант улиралд зах зээлийн нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.6 хувь буюу 5,671,979.62 мянган төгрөгөөр нэмэгдэж 64,625,037.33 мянган төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 94.7 хувь хүүгийн орлого, 1.8 хувь үйл ажиллагааны бусад орлого, 3.5 хувь үйл ажиллагааны бус орлого байна.

Зээлийн хүүгийн орлого 55,922,749.49 мянган төгрөг нь нийт орлогын 86.5 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 хувь буюу 2,458,306.55 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 23: ХЗХ-дын орлогын бүтэц /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны IV улирал		2023 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1. Хүүгийн орлого	**55,881,864.10**	**94.8%**	**61,204,159.42**	**94.7%**	**5,322,295.32**	**9.5%**
Зээлийн хүүгийн орлого	53,464,442.94	90.7%	55,922,749.49	86.5%	2,458,306.55	4.6%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	276,803.63	0.5%	435,657.76	0.7%	158,854.14	57.4%
Үнэт цаасны хүүгийн орлого	9,800.00	0.0%	8,115.99	0.01%	-1,684.01	0.0%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	2,461,902.00	4.2%	4,906,472.07	7.6%	2,444,570.07	99.3%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	11,793.10	0.0%	0.00	0.0%	-11,793.10	-100.0%
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	342,877.56	0.6%	68,835.89	0.1%	-274,041.66	-79.9%
2. Үйл ажиллагааны бусад орлого	**949,072.77**	**1.6%**	**1,181,087.71**	**1.8%**	**232,014.94**	**24.4%**
3. Үйл ажиллагааны бус орлого	**2,122,120.83**	**3.6%**	**2,239,790.20**	**3.5%**	**117,669.37**	**5.5%**
Нийт орлого	**58,953,057.71**	**100.0%**	**64,625,037.33**	**100.0%**	**5,671,979.62**	**9.6%**

5.2 ХЗХ-дын зардлын талаар

Зах зээлийн нийт зардлын хэмжээ 53,668,667.34 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувь буюу 6,331,982.76 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд хүүгийн зардал 63.7 хувь, үйл ажиллагааны зардал 30.0 хувь, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 4.0 хувь, үйл ажиллагааны бус зардал 0.2 хувийг тус тус эзэлж байна. Хүүгийн зардал 34,202,252.21 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.1 хувь буюу 3,960,548.33 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 24: ХЗХ-дын зардлын бүтэц /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны IV улирал		2023 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.Хүүгийн зардал	**30,241,703.88**	**63.9%**	**34,202,252.21**	**63.7%**	**3,960,548.33**	**13.1%**
Хадгаламжийн хүүгийн зардал	29,452,790.65	62.2%	32,850,230.68	61.2%	3,397,440.03	11.5%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	786,691.80	1.7%	1,337,784.39	2.5%	551,092.58	70.1%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.00
Бусад хүүгийн зардал	36,927.06	0.1%	39,902.45	0.1%	2,975.38	8.1%
(Хүүгийн зардлын буцаалт)	34,705.64	0.1%	25,665.31	0.0%	-9,040.33	-26.0%
2. Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	**1,614,109.78**	**3.4%**	**2,155,054.19**	**4.0%**	**540,944.41**	**33.5%**
Зээлийн эрсдэлийн зардал	1,672,373.83	3.5%	2,384,160.65	4.4%	711,786.82	42.6%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.00
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	58,264.05	0.1%	229,106.46	0.4%	170,842.41	293.2%
3. Үйл ажиллагааны зардал	**14,184,882.73**	**30.0%**	**16,103,393.81**	**30.0%**	**1,918,511.07**	**13.5%**
Боловсон хүчний зардал	9,027,601.50	19.1%	10,241,379.54	19.1%	1,213,778.04	13.4%
Бусад төрлийн зардал	5,157,281.23	10.9%	5,862,014.26	10.9%	704,733.03	13.7%
4. Үйл ажиллагааны бус зардал	**136,504.72**	**0.3%**	**97,766.02**	**0.2%**	**-38,738.70**	**-28.4%**
Татварын зардал	**1,159,483.47**	**2.4%**	**1,110,201.12**	**2.1%**	**-49,282.35**	**-4.3%**
Нийт зардал	**47,336,684.58**	**100.0%**	**53,668,667.34**	**100.0%**	**6,331,982.76**	**13.4%**
Цэвэр орлого	**11,616,373.13**	**100.0%**	**10,956,369.99**	**100.0%**	**-660,003.13**	**-5.7%**

5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт орлого 64,625,037.33 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.6 хувь буюу 5,671,979.62 мянган төгрөгөөр нэмэгдэж, нийт зардал 53,668,667.34 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувь буюу 6,331,982.76 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр цэвэр орлого 10,956,369.99 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувь буюу 660,003.13 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

График 11: ХЗХ-дын ашигт ажиллагаа /хувиар/



2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт орлогод эзлэх зардлын хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 пунктээр нэмэгдэж цэвэр орлогын эзлэх хувь буурсан байна.

Хүснэгт 25: ХЗХ-дын ашигт ажиллагаа /мянган төгрөгөөр/

	2022 оны IV улирал	2023 оны IV улирал
Нийт орлого	58,953,057.71	64,625,037.33
Нийт зардал	47,336,684.58	53,668,667.34
Нийт орлогод зардлын эзлэх хувь	80.3%	83.0%
Цэвэр орлого	11,616,373.13	10,956,369.99
Нийт орлогод цэвэр орлогын эзлэх хувь	19.7%	17.0%

ХЗХ-ны зах зээлийн нийт орлого 2019-2023 оны хооронд дунджаар 5.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

График 12: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/



ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХЗХ-дын 2023 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт"-ийг тооцоход дараах байдалтай байна.

6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 26: ХЗХ-дын шалгуур үзүүлэлт хангасан байдал

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
	Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт			
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	111,390.45 мян.төг (29 ХЗХ) -21,056.22 мян.төг (10 ХЗХ)	39	20.4%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	22	11.5%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	12	6.3%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	0	0.0%
	Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт			
5	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	61	31.9%
6	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	5	2.6%
7	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	25	13.1%
8	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	21	11.0%
9	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	4	2.1%
10	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	32	16.8%
11	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	34	17.8%
12	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	16	8.4%
13	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	17	8.9%
	Зардлын зохистой хэмжээ			
14	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	56	29.3%
	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар			
15	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	4%-аас доошгүй	40	20.9%
	Өгөөж, зардлын хувь хэмжээ			
16	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			3.6%

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ХЗХ-дын 15.2 хувь буюу 29 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 111,390.45 мянган төгрөгөөр илүү байгуулсан бол нийт ХЗХ-дын 5.2 хувь буюу 10 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 21,056.22 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна. Нийт ХЗХ-дын 11.5 хувь буюу 22 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 31.9 хувь буюу 61 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 13.1 хувь буюу 25 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 11.0 хувь буюу 21 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 16.8 хувь буюу 32 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 29.3 хувь буюу 56 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 20.9 хувь буюу 40 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

ХЗХ-ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 3.6 хувь байна.

Тайлант улиралд ХЗХ-дын 27.2 хувь буюу 52 ХЗХ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан бол 11.0 хувь буюу 21 ХЗХ 5 болон түүнээс дээш зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй байна.

Хүснэгт 27: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	ХЗХ-дын тоо	Хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	52	27.2%
2	1 ЗХШҮ хангаагүй	55	28.8%
3	2 ЗХШҮ хангаагүй	31	16.2%
4	3 ЗХШҮ хангаагүй	19	9.9%
5	4 ЗХШҮ хангаагүй	13	6.8%
6	5 ЗХШҮ хангаагүй	21	11.0%
	Нийт дүн	**191**	**100.0%**